Баянзүрх дүүргийн Статистикийн хэлтэс

# БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТАНИЛЦУУЛГА



Улаанбаатар хот

2016 он

## ЭРҮҮЛ МЭНД

2015 оны байдлаар дүүргийн эмнэлэгт 7774 эх амаржиж 7819 хүүхэд төрсөн нь 2014 онтой харьцуулахад 242 хүүхдээр буюу 3.4 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Хүснэгт-1. Эрүүл мэндийн зарим үзүүлэлтүүд

| Үзүүлэл | 2011 он | 2012 он | 2013 он | 2014 он | 2015 он |
|---|---|---|---|---|---|
| Төрсөн эх | 6195 | 6195 | 7498 | 7519 | 7774 |
| Шинээр төрсөн хүүхэд | 6229 | 6918 | 7561 | 7577 | 7819 |
| 0-1 насны хүүхдийн эндэгдэл | 78 | 70 | 93 | 102 | 103 |
| 1000 амьд хүүхдэд ногдох 0-1 насны эндэгдэл | 12.52 | 10.99 | 12.30 | 13.42 | 13.17 |
| 1-5 насны хүүхдийн эндэгдэл | 18 | 19 | 15 | 18 | 27 |
| 1000 амьд хүүхдэд ногдох 1-5 насны эндэгдэл | 2.89 | 2.75 | 1.98 | 2.38 | 3.45 |
| Эхийн нас баралт | 1 | 4 | 3 | 1 | 3 |
| 1000 амьд төрөлтөд ногдох эхийн эндэгдэл | 0.16 | 0.58 | 39.68 | 13.20 | 38.37 |
| Амгүй төрөлт | 32 | 53 | 56 | 50 | 59 |
| Гэрийн төрөлт | 24 | 24 | 24 | 26 | 28 |
| Хяналтгүй төрөлт | 25 | 27 | 31 | 31 | 22 |
| Нийт нас баралт | 1328 | 1420 | 1414 | 1362 | 1369 |
| Халдварт өвчнөөр өвчлөгсөд | 3764 | 5380 | 3901 | 4237 | 10273 |
| 10000 хүнд ноогдох халдварт өвчин | 148.19 | 195.89 | 135.0 | 141.0 | 335.00 |

0-1 насны хүүхдийн эндэгдэл 2015 онд 103 гарсан нь өмнөх онтой харьцуулбал 1 хүүхдээр буюу 1.0 хувиар өссөн бол 1-5 насны хүүхдийн эндэгдэл 2015 онд 27 гарч өмнөх оноос 50.0 хувиар буюу 9 хүүхдээр өссөн үзүүлэлтүүд гарчээ.

Эхийн эндэгдэл 2015 онд 3 тохиолдол гарсан бол өмнөх онтой харьцуулахад 2 эхээр буюу 3 дахин өссөн үзүүлэлттэй байна.

2014 онд 59 амьгүй төрөлт, 28 гэрийн төрөлт, 22 хяналтгүй төрөлт гарсан ба өмнөх онтой харьцуулахад амьгүй төрөлт 18.0 хувиар, гэрийн төрөлт 7.7 хувиар тус тус өсч, хяналтгүй төрөлт 29.0 хувиар буурсан байна.

Нийт нас барсан хүний тоо 1369 хүрч өмнөх оноос 7 хүнээр буюу 0.5 хувиар өссөн байна.

Зураг-1. Амгүй төрөлт, гэрийн төрөлт, хяналтгүй төрөлт, оноор




Зураг-2. Амаржсан эх, төрсөн хүүхэд, оноор



Хүснэгт-2. Төрсөн хүүхдийн тоо, дүүргээр

| Дүүрэг | 2011 он | 2012 он | 2013 он | 2014 он | 2015 он |
|---|---|---|---|---|---|
| Баянгол | 4206 | 4880 | 5217 | 5356 | 5446 |
| Баянзүрх | 6229 | 6918 | 7561 | 7577 | 7819 |
| Сүхбаатар | 3212 | 3467 | 3695 | 3840 | 3789 |
| Сонгинохайрхан | 6599 | 7264 | 7798 | 8596 | 8331 |
| Хан-уул | 2955 | 3407 | 3737 | 4091 | 4510 |
| Чингэлтэй | 3939 | 4400 | 4377 | 4505 | 4651 |
| Багануур | 715 | 769 | 864 | 782 | 650 |
| Багахангай | 74 | 92 | 82 | 95 | 75 |
| Налайх | 892 | 930 | 971 | 1012 | 1026 |
| Улаанбаатар | 28821 | 32127 | 34302 | 35854 | 36297 |
| Улаанбаатар хотын дунд Баянзүрх дүүргийн эзлэх хувийн жин | 21.6 | 21.5 | 22.0 | 21.1 | 21.5 |

Зураг-1. Төрсөн хүүхдийн тоо, дүүргээр




Сүүлийн 5 жилийн байдлаар дүүрэгт жилд дунджаар 7221 хүүхэд төрсөн байна. Улаанбаатар хотод төрсөн нийт 36297 хүүхдийн 7819 нь буюу 21.5 хувь нь Баянзүрх дүүрэгт төрсөн байна.

2015 онд төрсөн 7819 хүүхдийн тоог өмнөх онтой харьцуулахад 3.2 хувиар буюу 242 хүүхдээр өссөн байна.

Төрсөн хүүхдийн тоог сүүлийн 5 жилээр авч үзвэл жилд дунджаар 6.6 хувиар өссөн бол 2011-2012 оны хооронд хамгийн өндөр буюу 11.1 хувиар өссөн байна.

Улаанбаатар хотын дунд төрсөн хүүхдийн тоогоор эзлэх хувийн жинг нь ажиглавал 2011 онд 21.6 хувь, 2012 онд 21.5 хувь, 2013 онд 22.0 хувь, 2014 онд 21.1 хувь, 2015 онд 21.5 хувийг эзэлж байна.

Зураг-3. Төрсөн хүүхдийн тоо, дүүргээр



Хүснэгт-1. 0-1 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл, 1000 амьд хүүхдэд ноогдох эндэгдэл, дүүргээр

| Дүүрэг | 2011 он | | 2012 он | | 2013 он | | 2014 он | | 2015 он | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Тоо | 1000 амьд хүүхдэд ноогдох | Тоо | 1000 амьд хүүхдэд ноогдох | Тоо | 1000 амьд хүүхдэд ноогдох | Тоо | 1000 амьд хүүхдэд ноогдох | Тоо | 1000 амьд хүүхдэд ноогдох |
| Баянгол | 47 | 11.17 | 33 | 6.76 | 49 | 9.39 | 56 | 10.46 | 53 | 9.73 |
| Баянзүрх | 78 | 12.52 | 76 | 10.99 | 93 | 12.30 | 102 | 13.46 | 103 | 13.17 |
| Сүхбаатар | 41 | 12.76 | 31 | 8.94 | 41 | 11.10 | 38 | 9.90 | 41 | 10.82 |
| Сонгино-хайрхан | 66 | 10.00 | 79 | 10.88 | 93 | 11.93 | 117 | 13.61 | 121 | 14.52 |
| Хан-уул | 22 | 7.45 | 37 | 10.86 | 48 | 12.84 | 45 | 11.00 | 41 | 9.09 |
| Чингэлтэй | 39 | 9.90 | 53 | 12.05 | 49 | 11.19 | 53 | 11.76 | 49 | 10.54 |
| Багануур | 8 | 11.19 | 11 | 14.30 | 8 | 9.26 | 12 | 15.35 | 7 | 10.77 |
| Багахангай | 3 | 40.54 | 0 | 0.00 | 0 | 0.00 | 2 | 21.05 | 1 | 13.33 |
| Налайх | 18 | 20.18 | 20 | 21.51 | 17 | 17.51 | 15 | 14.82 | 16 | 15.59 |

Баянзүрх дүүрэгт 0-1 насны хүүхдийн эндэгдэл 103-т хүрч өмнөх оноос 1.0 хувиар буюу 1 хүүхдээр өссөн байна. Мөн Улаанбаатар хотын 9 дүүрэгтэй харьцуулахад 0-1 насны хүүхдийн эндэгдлийн тоогоор Сонгинохайрхан дүүргийн дараагаар 2 дугаарт орж байна.

Хүснэгт-1. 1-5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл, 1000 амьд хүүхдэд ноогдох эндэгдэл, дүүргээр

| Дүүрэг | 2011 он | | 2012 он | | 2013 он | | 2014 он | | 2015 он | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Тоо | 1000 амьд хүүхдэд ноогдох | Тоо | 1000 амьд хүүхдэд ноогдох | Тоо | 1000 амьд хүүхдэд ноогдох | Тоо | 1000 амьд хүүхдэд ноогдох | Тоо | 1000 амьд хүүхдэд ноогдох |
| Баянгол | 5 | 1.19 | 8 | 1.64 | 8 | 1.53 | 6 | 1.12 | 6 | 1.10 |
| Баянзүрх | 18 | 2.89 | 19 | 2.75 | 15 | 1.98 | 18 | 2.38 | 27 | 3.45 |
| Сүхбаатар | 7 | 2.18 | 7 | 2.02 | 11 | 2.98 | 5 | 1.30 | 7 | 1.85 |
| Сонгино-хайрхан | 16 | 2.42 | 17 | 2.34 | 15 | 1.92 | 23 | 2.68 | 23 | 2.76 |
| Хан-уул | 6 | 2.03 | 6 | 1.76 | 9 | 2.41 | 13 | 3.18 | 5 | 1.11 |
| Чингэлтэй | 9 | 2.28 | 13 | 2.95 | 12 | 2.74 | 12 | 2.66 | 4 | 0.86 |
| Багануур | 4 | 5.59 | 3 | 3.90 | 2 | 2.31 | 1 | 1.28 | 0 | 0.00 |
| Багахангай | 0 | 0.00 | 0 | 0.00 | 1 | 12.20 | 0 | 0.00 | 0 | 0.00 |
| Налайх | 2 | 2.24 | 1 | 1.08 | 8 | 8.24 | 4 | 3.95 | 1 | 0.97 |

Баянзүрх дүүрэгт 1-5 насны хүүхдийн эндэгдэл 27-д хүрч өмнөх оноос 50.0 хувиар буюу 9 хүүрдээр өссөн байна. Мөн Улаанбаатар хотын 9 дүүрэгтэй харьцуулахад 1-5 насны хүүхдийн эндэгдлийн тоогоор нэгдүгээрт орж байна.

2015 онд халдварт өвчнөөр өвчилсөн хүний тоо 10273 болж өнгөрсөн оны мөн үеийнхээс 2.4 дахин буюу 6036 хүнээр өссөн байна.

Баянзүрх дүүргийн хэмжээнд 10000 хүн амд ноогдох халдварт өвчний тоо 2015 онд 335.0 өмнөх оны мөн үед 141.00 байсан нь 2.3 дахин буюу 194.00-ээр өссөн байна.

Хүснэгт 1. Халдварт өвчин, 10000 хүн тутамд ноогдох халдварт өвчний тоо

| Үзүүлэлт | Хэмжих нэгж | 2011 он | 2012 он | 2013 он | 2014 он | 2015 он |
|---|---|---|---|---|---|---|
| Халдварт өвчнөөр өвчилсөн хүн бүгд, үүнээс: | бодит тоо | 3764 | 5380 | 3901 | 4237 | 10273 |
| | 10000 хүнд | 148.19 | 195.89 | 135.00 | 141.00 | 335.00 |
| Вируст гепатит | бодит тоо | 907 | 498 | 215 | 135 | 138 |
| | 10000 хүнд | 35.71 | 18.13 | 7.4 | 4.51 | 4.50 |
| Менингит | бодит тоо | 1 | 2 | 6 | 0 | 1 |
| | 10000 хүнд | 0.04 | 0.07 | 0.21 | 0.00 | 0.03 |
| Цусан суулга | бодит тоо | 471 | 456 | 479 | 588 | 696 |
| | 10000 хүнд | 18.54 | 16.60 | 16.57 | 19.63 | 22.71 |
| Салхин цэцэг | бодит тоо | 506 | 494 | 757 | 750 | 1142 |
| | 10000 хүнд | 19.92 | 17.99 | 26.18 | 25.03 | 37.26 |
| Гахай хавдар | бодит тоо | 144 | 2064 | 362 | 77 | 56 |
| | 10000 хүнд | 5.67 | 75.15 | 12.52 | 2.57 | 1.83 |
| Сальмонеллёз | бодит тоо | 25 | 23 | 16 | 20 | 37 |
| | 10000 хүнд | 0.98 | 0.84 | 0.55 | 0.67 | 1.21 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| Улаан эсэргэнэ | бодит тоо | 17 | 26 | 92 | 96 | 198 |
| | 10000 хүнд | 0.67 | 0.95 | 3.18 | 3.20 | 6.46 |
| Хоолны хордлого | бодит тоо | 36 | 117 | 37 | 51 | 85 |
| | 10000 хүнд | 1.42 | 4.26 | 1.28 | 1.70 | 2.77 |
| Ёлом | бодит тоо | 34 | 32 | 23 | 30 | 23 |
| | 10000 хүнд | 1.34 | 1.17 | 0.80 | 1.00 | 0.75 |
| Бруцеллёз | бодит тоо | 5 | 58 | 1 | 6 | 5 |
| | 10000 хүнд | 0.20 | 2.11 | 0.03 | 0.20 | 0.16 |
| Нярайн халдвар | бодит тоо | 7 | 12 | 0 | 2 | 0 |
| | 10000 хүнд | 0.28 | 0.44 | 0.00 | 0.07 | 0.0 |
| Гар хөл амны өвчин | бодит тоо | 3 | 0 | 361 | 555 | 407 |
| | 10000 хүнд | 0.12 | 0.00 | 12.49 | 18.52 | 13.28 |
| Тэмбүү | бодит тоо | 194 | 123 | 522 | 633 | 681 |
| | 10000 хүнд | 7.64 | 4.48 | 18.06 | 21.13 | 22.22 |
| Заг хүйтэн | бодит тоо | 466 | 443 | 133 | 187 | 204 |
| | 10000 хүнд | 18.35 | 16.13 | 4.60 | 6.24 | 6.66 |
| Трихомониаз | бодит тоо | 200 | 165 | 359 | 438 | 423 |
| | 10000 хүнд | 7.87 | 6.01 | 12.42 | 14.62 | 13.80 |
| Шинээр илэрсэн сүрьеэ | бодит тоо | 258 | 335 | 530 | 644 | 580 |
| | 10000 хүнд | 10.16 | 12.20 | 18.33 | 21.49 | 18.92 |
| Бусад | бодит тоо | 490 | 532 | 8 | 25 | 5597 |

2015 онд дүүргийн хэмжээнд нийт 10273 халдварт өвчин гарсны 87.3 хувь нь буюу 8965 нь цоцмог халдварт өвчин үлдсэн 12.7 хувь нь буюу 1308 нь бэлгийн замын халдварт өвчин байна.

Цочмог халдварт өвчний тоо 2015 онд 8965-т хүрч өмнөх оноос 2.4 дарин буюу 6036 өвчлөлөөр өссөн байна. Халдварт өвчин 2.4 дахин өсөхөд улаан бурхан өвчний дэгдэлт нэмэгдэн 5533 тохолдол бүртгэгдсэн байдал илүүтэй нөлөөлжээ.

Нийт халдварт өвчний 1.3 хувийг буюу 138 нь вируст гепатит өвчин, 6.8 хувийг буюу 696 нь цусан суулга өвчин, 11.2 хувийг буюу 1142 нь салхин цэцэг өвчин, 0.5 хувийг буюу 56 нь гахайн хавдар өвчин, 0.4 хувь нь буюу 37 нь сальмонеллёз өвчин, 1.9 хувь буюу 198 нь улаан эсэргэнэ өвчин, 0.8 хувь нь буюу 85 нь хоолны хордлого өвчин, 0.2 хувь нь буюу 23 нь ёлом өвчин, 0.1 хувь нь буюу 5 нь бруцеллёз өвчин, 4.0 хувь нь буюу 407 нь гар, хөл, амны өвчин, 6.6 хувь нь буюу 681 нь  тэмбүү өвчин,  2.0 хувь нь буюу 204 нь заг хүйтэн өвчин, 4.1 хувь нь буюу 423 нь трихомониаз өвчин,  5.6 хувь нь буюу 580 нь шинээр илэрсэн  сүрьеэ өвчин, 54.5 хувь нь буюу 5597 нь  бусад өвчин эзлэж байна.

Зураг-1. Нийт халдварт өвчин, бүтцээр



Бэлгийн замын халдварт өвчиний 52.1 хувь нь буюу 681 нь тэмбүү өвчин, 15.6 хувь буюу 204 нь заг хүйтэн өвчин, үлдсэн 32.3 хувь нь буюу 423 нь трихомониаз өвчин тус тус эзлэж байна.

2015 онд бүртгэгдсэн бэлгийн замын халдварт өвчин 1308-д хүрч өмнөх оноос 4.0 хувиар буюу 50 тохиолдолоор өсчээ.

Зураг-1. Бэлгийн замын халдварт өвчин, бүтцээр




Тэмбүү өвчний гаралт 2015 онд 681-д хүрч өмнөх онтой харьцуулахад 7.6 хувиар буюу 48 тохиолдлоор, заг хүйтэн өвчин 204-д хүрч 9.1 хувиар буюу 17 тохиолдлоор тус тус өсч, трихомониаз өвчин 423-д хүрч 3.4 хувиар буюу 15 тохиолдолоор буурсан байна.

Сүүлийн 5 жилийн байдлаар авч үзвэл тэмбүү өвчинд ажиглалт хийхэд 2011-2012 оны хооронд 36.6 хувиар буурах хандлагатай байсан бол, 2012-2013 оны хооронд 4.2 дахин огцом, 2013-2014 оны хооронд 21.3 хувиар, 2014-2015 оны хооронд 7.6 хувар тус тус өсч буцаад өсөх хандлага ажиглагдаж байна.

Заг хүйтэн өвчинг сүүлийн 5 жилээр авч үзвэл жилд дунджаар 287 тохиолдол гарч 4.7 хувиар өссөн байна.

Трихомониаз өвчний хувьд 423 тохиолдол бүртгэгдэж сүүлийн 5 жилийн дундаж өсөлт 19.0 хувь байна.

2015 оны байдлаар дүүргийн нийт хүн амын 0.4 хувь нь буюу 245 хүн тутмын 1 нь бэлгийн замын халдварт өвчнөөр өвчилсөн байна.

Зураг-1. Халдварт өвчний тоо, шинээр илэрсэн сүрьеэ өвчин




Зураг-1. Халдварт өвчний тоо, вируст гепатит өвчин




Шинээр илэрсэн сүрьеэ өвчин 2015 онд 580 гарч өмнөх онтой харьцуулахад 64 өвчлөлөөр буюу 9.9 хувиар өссөн бол сүүлийн 5 жилийн дунджаар авч үзвэл жилд дунджаар 10.3 хувиар өссөн байна.

Вируст гепатит өвчин 138 болж өмнөх оноос 2.2 хувиар буюу 3 өвчлөлөөр өссөн байна.

Зураг-1. Халдварт өвчин, салхин цэцэг өвчин




Зураг. Халдварт өвчин, цусан суулга өвчин




2015 онд салхин цэцэг өвчин 1142 гарч өмнөх оноос 392 оор буюу 52.3 хувиар, цусан суулга өвчин 696 гарч 108-өөр буюу 18.4 хувиар тус тус өссөн байна.

Сүүлийн 5 жилийн байдлаар авч үзвэл жилд дунджаар 730 салхин цэцэг өвчин, 538 цусан суулга өвчин гарсан байна.

Минингит өвчин 2013 онд хамгийн өндөр буюу 6 тохиолдол гарсан бол тайлант онд буюу 2015 онд тус өвчин 1 гарсан бол гахайн хавдар өвчин 2015 онд 56 гарсан нь өмнөх онтой харьцуулахад 21-ээр буюу 27.3 хувиар буурсан, мөн сальмонеллёз өвчин 2015 онд 37 гарч өмнөх оноос 17-оор буюу 85.0 хувиар, улаан эсэргэнэ өвчин 2015 онд 198 гарч өмнөх оноос 102-оор буюу 2 дахин, хоолны хордлого 2015 онд 85 бүртгэгдэж өмнөх оноос 34-өөр буюу 66.6 хувиар тус тус өссөн бол, ёлом өвчин 2015 онд 23 гарч өмнөх 7 оор буюу 23.3 хувиар , бруцеллёз өвчин 2015 онд 5 гарч өмнөх оноос 1-ээр буюу 16.7 хувиар, гар хөл амын өвчин 2015 онд 407 гарч өмнөх оноос  148-аар буюу 26.7 хувиар тус тус буурч нярайн халдвар 2015 онд бүртгэгдээгүй байна.

Бэлтгэсэн: Статистикийн хэлтсийн мэргэжилтэн

Б.Цэвэлмаа

Хянасан: Хэлтсийн дарга /Н.Энхтуяа/

БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС